

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ТОВЧ ТАЙЛАН  
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдаан 02 дугаар сарын 23-ны өдөр болж, хурлаар 15 асуудал хэлэлцлээ. VI хуралдаанд танхимаар 37 төлөөлөгч, цахимаар 2 төлөөлөгч оролцож 95.1 хувийн ирцтэй хуралдлаа.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Шадар суурин төлөөлөгч Аяако Кайно, Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар нар "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөр хэрэгжүүлэхээр 2022 оны хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарын санаачлагаар төрийн албанд анх томилогдсон 18 сум, 88 баг, 2 тосгоны нийт 450 албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийн болон хувь хүний хөгжлийн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулах" зорилгоор чадавхжуулах сургалтыг 02 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, баталгаажууллаа.

Гэрээний хүрээнд Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Говь-Алтай аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон эдгээр хөтөлбөрүүдийн тэргүүлэх дөрвөн чиглэл болох "Боловсролын чанарыг сайжруулах", "Газар тариалан, жимс жимсгэнэ", "Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил", "Аялал жуулчлалыг хөгжүүлэх" төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, биелэлтийг дүгнэх юм.

Алтай хотыг 2015-2030 онд хөгжүүлэх "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г тодотгох, зөвлөх баг орон нутагт ажиллаж суурь судалгаа, төлөвлөлтийн шийдэл, цаашдын тэргүүлэх чиглэлийн талаар аймгийн удирдлагуудтай уулзаж санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар" хамтран "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" сэдэвт хэлэлцүүлгийг жендэр, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны албан хаагч, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж, үлгэрлэн манлайлж буй төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг хамруулан зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу аймгийн Засаг дарга, түүний тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тэмдэглэлийн хамт ЗГХЭГ-т хүргүүллээ

**Төрийн үйлчилгээний чиглэлээр:** Үйлчилгээний нэгдсэн төвд 6 байгууллагын 12 албан хаагч 02 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 1169 иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэн ажиллалаа.

**Өргөдөл гомдлын талаар:** Тайлант хугацаанд аймгийн Засаг даргад хандан 5, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад 2 нийт 7 өргөдөл бичгээр ирснээс 2 өргөдлийг шийдвэрлэж, 5 өргөдөл хяналтын хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт 28,5% байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 2 дугаар сарын байдлаар 18 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

**Цахим үйлчилгээний талаар:** E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 13 байгууллагын 64 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар, биеийн давтагдашгүй өгөгдөл болох хурууны хээгээр олгож байна.

Тайлант хугацаанд операторын системээр иргэдэд олгох боломжтой 64 төрлийн төрийн цахим мэдээллийн үйлчилгээг 17 иргэнд төлбөртэй, 75 иргэнд төлбөргүй, нийт 92 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

Иргэдийн хүсэлтээр ДАН танилт нэвтрэлтийн систем ашиглан, хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 63 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

#### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хүний эрхийн үндэсний комиссоос Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад хийсэн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж, хамрагдлаа.

Орон нутгийн чиг үүргийг эрчимжүүлэх үйл ажиллагааг дэмжих “Засагт Хан” орон нутгийн сангийн журмыг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 15-ны дотор тус аймгийн хэмжээнд хуулийн хугацаанд 232 мэдүүлэг гаргагч 100 хувьтай мэдүүллээ.

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 21 заалтын биелэлтийг <http://khutulbur.iaac.mn/> цахим системд оруулж баталгаажуулж, 2021 оны жилийн эцсийн биелэлтийг 95,5 хувьтайгаар тооцож, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 5/210 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүллээ.

Сумдын Засаг дарга нарын тогтмол гаргадаг 38 төрлийн захирамжийн лавлахыг, тайлбарын хамт боловсруулж сумдын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

#### **Архивийн тасаг:**

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 128 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар хуудас баримт хувилж олшруулан, үнийн тарифын дагуу 1388000 төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд шилжүүлж иргэдэд үйлчилгээ үзүүллээ. E-archives.gov.mn программаар нийт 13 иргэний захиалгыг хүлээн авч, хариуг шийдвэрлэж хүргүүллээ.

АЕГ-аас ирсэн бичгийн дагуу 237 хөмрөгийн нэрийн өөрчлөлтийг эх баримттай нь тулгаж, баталгаажсан мэдээллийг [tsahim.medee@arvhives.gov.mn](mailto:tsahim.medee@arvhives.gov.mn) цахим шуудангаар болон албан тоотоор илгээлээ.

Архивын Ерөнхий Газрын цахим сургалтанд нийт албан хаагчид хамрагдаж, Архивын Ерөнхий газрын 2022.01.12. ны өдрийн 01/20-дугаар албан бичгийн дагуу хөмрөгийн нэрийн өөрчлөлтийг [e-document.gov.mn](http://e-document.gov.mn) цахим системд бүртгэж баталгаажуулах ажлыг эхлэн хуваарь гарган 7 албан хаагч 246 байгууллага

нэгжийн хөмрөгийн нэрийн өөрчлөлтийн материалыг 33 хөмрөгийн баримт бүрдүүлэн одоогийн байдлаар 132 нэгжийн хөмрөгийн нэрийн өөрчлөлтийг зохих журмын дагуу цахим системд бүртгэлээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** 379 гүйцэтгэх хуудасны 2.965.624,5 мянган төгрөгийг биелүүлэхээс 70 гүйцэтгэх баримт бичгийн 197.884,7 мянган төгрөгийг биелүүлж, 96216,0 мянган төгрөгний гүйцэтгэх баримт бичгийг бодитойгоор бүрэн, хэсэгчлэн 64 гүйцэтгэх баримт бичгийн 101.668,7 мянган төгрөгийг тус тус биелүүлэн, 309 гүйцэтгэх баримт бичгийн 2,767.739,8 мянган төгрөгний үлдэгдэлтэй бодит биелэлт 18,4 хувийг биелүүлэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,2 хувиар өсгөн ажилласан байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тайлант сард эрүүгийн хэрэгт мөрдөгч, прокурорын тогтоолийг үндэслэн 3, эрх бүхий бусад байгууллага албан тушаалтны хүсэлтээр 1 криминалистикийн шинжилгээ хийсэн. Хэргийн газрын үзлэгт 32 удаа оролцосноос хүний амь нас хохирсон 4, хулгайлах 5, зам тээврийн ослын 8, бусад 15 хэрэгт үзлэг шинжилгээ хийсэн байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Өнгөрсөн хугацаанд 311 лавлагаа олгож, гадаад паспорт захиалга 18, шинээр бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээ авсан 11, дахин олгосон 4, нийт 15 хуулийн этгээдийг бүртгэн гэрчилгээ олгосон.

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 168 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэв.

Тус хугацаанд улсын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 17 иргэнд 310,000 төгрөгийн торгууль ноогдуулсан. Мөн иргэний бүртгэлийн чиглэлээр 10, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 2, хуулийн этгээд 3, нийт 15 дүгнэлтээр 91 бүртгэлийн зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.

#### ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

**Аймгийн төсөв санхүүгийн чиглэлээр:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдаанаар 2022 оны төсвийн тодотголыг батлуулж ажиллалаа.

Төсвийн байгууллагын 3 дугаар сарын цалингийн гүйлгээ цахимаар хийгдэж эхлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг ханган Эрхийн бүртгэлийн санд тохиргоо хийгдээгүй дансны тохиргоо хийж, сумдыг мэдээллээр хангаж цахим гүйлгээний бэлтгэл ажлыг хангалаа.

Шинээр нээгдсэн Улсын төсөв болон Орон нутгийн төсвийн дансуудыг Фрийбаланс, Цалингийн нэгдсэн систем, Эрхийн бүртгэлийн санд тохируулан, сум байгууллага тус бүрт И-хуулгад хандах эрхийг нь олголоо.

Нэмэлт санхүүжилтийн 24 байгууллагын 75.7 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээлээ.

**Худалдан авах ажиллагаа:** 2 дугаар сард ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжих 4, улсын төсвөөс санхүүжих 1, орон нутгийн төсвөөс санхүүжих 1 нийт 6 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа. Мөн улсын төсвийн хөрөнгөөр 1, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2, аймгийн ОНХС-н хөрөнгөөр 3 ажлын тендер шалгаруулж, захиалагчид зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа. Үнэлгээний шатанд улсын төсөв 2, ОНХС 2 ажил үргэлжилж байна.

**Өмчийн харилцааны талаар:** Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 98 дугаар тогтоолын дагуу 3 нээлттэй дуудлага худалдааг зарлаж “Алтай радио”, “Өнөөдөр сонин”-д зарыг байршууллаа.

#### **ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

**Хөдөө аж ахуйн салбарт:** “Газар тариалан жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээний хүрээнд 2022 онд батлагдсан төсвийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан мод үржүүлгийн талбайд дуслын услалтын систем нийлүүлэх болон модны үр үрсэлгээ нийлэх ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан ажиллалаа.

“Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээ болон “108 сая мод тарьж, ургуулах аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын зөвлөх болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ахлуулсан 2 ажлын хэсэг гарч 18 сум 2 тосгонд цаг үеийн асуудлаар сумдын удирдлагуудтай уулзаж, хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд тариалан эрхлэгчдэд шаардлагатай үр, суулгац, хашлага хамгаалалт болон “108 сая мод тарьж, ургуулах аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт, ойжуулалт хийх ойн зурвас байгуулах цэгийг тогтоох усан хангамжийн хүрэлцээ зэрэгтэй газар дээр нь танилцаж санал солилцон ажиллалаа.

Сумдад том малын зүй бус хорогдол гараагүй ба эх мал төллөлт эхэлсэн. 2022 оны 2 дугаар сарын дүнгээр аймгийн хэмжээнд нийт 1400,0 эх мал төллөөд байна. Үүнд: гүү-43,0, үнээ-31,0, ингэ-16,0, эм хонь-400,0, эм ямаа-900,0 мянган толгой;

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн санхүүжилтээр Цогт сумд 2, Дэлгэр, Бигэр, Тайшир сумд тус бүр 1 нийт 5 инженерийн хийцтэй худаг гаргах байршил, цэгийг ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Шүлхийн өвчлөл аймгийн хэмжээнд нийтдээ 11 сум, 28 баг, 30 голомт, 212 өрхөд халдвар бүртгэгдэж, 1058-үхэр, 3666-хонь, 4565-ямаа, нийт 9292 мал өвчилсөн.

Өвчилсөн малаас 1058-үхэр, 3540-хонь, 4412-ямаа, нийт-9010 мал буюу 96.9%-д эмнэлзүйн шинж тэмдэг арилсан ба өнөөдрийн байдлаар 11 өрхийн 278 мал шинж тэмдэгтэй байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:** Аймгийн хэмжээний Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн мэдээллийг нэгтгэн Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээсэн.

#### **ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

**Газрын харилцааны чиглэлээр:** Газрын төлбөрийн тухай хуульд 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдөр нэмэлт өөрчлөлт орж хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж өөрчлөлт орж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон тул газрын төлбөрийн үнэлгээний бүс, хувь хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

**Нийтийн аж ахуйн талаар:** Алтай хотын урд чиглэлийн цэвэр усны шугам сүлжээнд гэмтэл гарч энэ сарын 20-ны өдөр төв цэвэр усыг хязгаарлаж, 20-ны өдрөөс 22-ны өдрүүдэд засвар үйлчилгээ хийж хэвийн горимд орууллаа.

1-р сургуулийн болон 6-р цэцэрлэгийн урд байрлах худаг болон хойд чиглэлийн бохир усны шугам бөглөрч давсан тул халдварт өвчин тархах эрсдэл үүсэхээс сэргийлж кальцийн гипохлорид хуурай болон 10% уусмалаар халдваргүйжүүлэлт хийлээ.

**Агаарын тээвэр:** 2022 оны 2 дугаар сард нийт 6 удаа нислэг үйлдэгдсэн. Алтай-Улаанбаатар чиглэлд 94 зорчигч, 681 кг тээш, Улаанбаатар-Алтайн чиглэлд 89 зорчигч, 829 кг тээш тээвэрлэсэн байна. Завхан, Говь-Алтай аймгуудын дунд 3 нислэг явагдсан.

**Техникийн хяналтын үзлэг:** 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийг хүртэл техникийн хяналтын үзлэгт нийт 234 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас суудлын автомашин-62, ачааны машин-29, автобус-24, чиргүүл-3, мотоцикл-10, зүтгүүр-2, цистерн-1, механизм-2, тусгай-1 ширхэг тус тус хамрагдсан байна.

**Хот хоорондын зорчигч тээвэрлэлт:** Тайлант сард нийт 2650 орчим иргэдэд хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн талаарх мэдээлэл хүргэж, зорчих тасалбар олгож үйлчилсэн байна.

Тайлант хугацаанд 37 удаагийн зорчигч тээвэрлэлтээр Говь-Алтай-Улаанбаатар чиглэлд 1908 зорчигч, Улаанбаатар-Говь-Алтай чиглэлд 705 зорчигч нийт 2613 зорчигч хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ авсан байна.


#### ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР

**Боловсролын чиглэлээр:** БШУЯ, Боловсролын Ерөнхий газраас ирүүлсэн тушаал, чиглэл, зөвлөмжийг аймгийн 28 сургууль, 30 цэцэрлэгт албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах талаар 2 удаагийн онлайн сургалтыг сургуулийн удирдлага нийт 120 хүнд зохион байгууллаа.

Хичээлийн жилийн 2 дугаар улирлын хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэх бэлэн байдлыг хангах чиглэлээр сургуулийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч нийт 94 хүнд онлайн уулзалт зохион байгууллаа.

Хүний нөөцийн дутагдалтай багшийн судалгааг гаргаж 16 багшийн ажлын байрны захиалгыг цахим хуудсанд байршуулж, нөөцөд байгаа багшийн судалгааг шинэчлэн 6 багшийг ажлын байраар хангалаа.

02 дугаар сарын 18-нд Монгол хэл бичгийн багш нарт цахим уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар монгол хэл бичгийн шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтын талаарх мэдээлэл, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг танилцуулж, судлагдахууны мэргэжлийн бүлгийг байгуулан, ажлын байран дээрээ хөгжих, бие даан гүйцэтгэх даалгавруудыг танилцуулж, хуваарилалт зохион байгуулалт хийлээ.



Говь-Алтай аймгийн ЭЕШ өгөх 12 дугаар ангийн 619 сурагчийн эцэг эхчүүдэд зориулан Говь-Алтай аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас Боловсролын үнэлгээний төв, Боловсролын зээлийн сан, Шинэ эрин олон улсын сургууль, ГБХЗХГ-тай хамтран онлайн зөвлөгөөн зохион байгуулав.

MIU сургуулийн Америк багш нартай хамтран Есөнбулаг сумын 1, 2, 3, 4, ХЭЦС-ийн 7-9 дүгээр ангийн 540 сурагчдад ярианы клуб, 10-12 дугаар ангийн 525 сурагчид англи хэлний ЭЕШ-д бэлтгэх сургалтыг 7 хоног бүр хуваарийн дагуу зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ажилтан, эцэг эхийн зөвлөлийн төлөөллийг “Коронавируст цар тахлын үеийн халдвар хамгаалал ба эцэг, эхийн оролцоо” сэдвээр сургагч багшаар бэлтгэх цахим сургалтад хамрагдлаа. Цэцэрлэг, сургуулийн цахим сургалтын бүртгэлийг хийж амжилттай зохион байгуулж, цэцэрлэгийн 62 эцэг эх, 31 ажилтан нийт 93, сургуулийн 30 ажилтан, 58 эцэг эх, нийт 88 нийлбэр дүнгээр 181 хүнийг хамруулан сургагч багшаар бэлтгэлээ.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** 2-р дугаар сарын 1-ны өдрөөс 28-ны өдрүүдэд коронавирусаар батлагдсан хүний ойрын хавьтлын 6655 иргэнийг шинжилгээнд хамруулсанаас аймгийн хэмжээнд нийт батлагдсан тохиолдолын тоо 18428 үүнээс энэ сард батлагдсан 2743 хүн эерэг гарч 8229 хүнийг гэрийн ажиглалтанд авлаа.

КОВИД-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд 2 хүн хамрагдаж өссөн дүнгээр 39272, 2-р тунд 10 хүн хамрагдаж өссөн дүнгээр 37661, 3-р тунд 138 хүн хамрагдаж өссөн дүнгээр 16484, 4-р тунд 223 хүн хамрагдаж өссөн дүнгээр 1305 хүн хамрагдлаа.

Цагаан сарын баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрсдлээс сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны “Хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай” А/04 дүгээр тушаалын дагуу 2 дугаар сарын 02-ны өдрөөс 07-ны өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон ажиллууллаа.

Аймгийн хэмжээнд цагаан сарын баярын өдрүүдээр 9 эх эсэн мэнд амаржиж, 9 хүүхэд амьд төрлөө. Амбулаториор 325 хүн үйлчлүүлж, түргэн тусламжийн дуудлагаар 166 хүн тусламж үйлчилгээг хүлээгдэлгүйгээр хүргэж ажиллалаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 оны 2 сарын 01-ний өдрөөс 25-ны өдрийн хооронд 2897 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 28 байсан ба нас баралтын 1 тохиолдол бүртгэгдлээ.

Амбулаториар нийт 4842 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, томуу төст өвчинтэй 35 тохиолдол бүртгэгдлээ. Энэ хугацаанд нийт 47 эх эсэн мэнд амаржиж 37 хүүхдийг хүлээн авч, нярайн эндэгдэл 1 бүртгэгдлээ.

Нийт 43 мэс засал хийснээс мэс заслын тасагт 22, гэмтлийн тасагт 11, төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 10 байлаа. Түргэн тусламжийн 294 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 380 хүн өөрөө ирж үзүүлснээс томуу, томуу төст өвчний 32 тохиолдол бүртгэгдлээ. Алсын дуудлагын 10 тохиолдолд Халиун, Бигэр, Хөхморьт, Цогт, Баян-Уул, Цээл сумдад, Гуулин тосгон, Рашаант багт үйлчиллээ.

**Соёлын чиглэлээр:** “Угийн бичиг-Удмын хэлхээ” аяны хүрээнд аймгийн Засаг даргын ивээл дор шилдэг угийн бичиг хөтөлсөн сум, байгууллага, өрх шалгаруулах уралдааны удирдамж, төлөвлөгөө боловсруулан, угийн бичиг хөтлөх

арга зүйн чиглэлээр бүх сумдад сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ICH.MONGOL.MN программыг ашиглах тухай гэрээг шинэчлэн байгуулж, Соёлын өвийн Үндэсний төвд хүргүүлээ.

Албан хаагчдын гар дээр хадгалагдаж байгаа өв, үнэт өвийн үзэсгэлэнг зохион байгуулж, 3 буюу түүнээс дээш үед өвлөн уламжлагдаж ирсэн үнэт өвүүдэд “Батламж” гардуулж, бүртгэлжүүлээ.

Соёлын яам, Төрийн албаны зөвлөл хамтран 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан цахим сургалтад 4 албан хаагч, аймгийн ЗДТГ-ын 02 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ардчилсан засаглал, Алтайчуудын хөгжил” сургалт, хэлэлцүүлэгт 4 албан хаагч тус тус хамрагдаж, чадавхжлаа.

**Нийтийн номын сан:** 02 дугаар сард 122 шинэ уншигч бүртгэн 749 ирцэд 1656 ном олгож үйлчлэв. Уншигчдад аман болон бичгийн 12 лавлагаа, 17 татгалзал бүртгэн үйлчиллээ. Гэрээр ном олгох тасаг, Уншлага үйлчилгээний 3 танхимаас нийт 59 ширхэг ном сэргээн засварлаж уншигчдад үйлчиллээ. Эх орончдын өдөр, Олон Улсын Эмэгтэйчүүдийн өдөрт зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 70 ш номоор гарган уншигчдад сурталчилан ажиллалаа.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага:** Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн захирамжийн дагуу Есөнбулаг сумын ЗДТГазартай хамтран “ХҮҮХДЭЭ СОНСОХ ӨДӨР” арга хэмжээг зохион байгуулж, Есөнбулаг сумын ЕБС-ын 5 сургууль, МСҮТ, Лицей сургуулиудаас тус бүр төлөөлөл 68 сурагч хамрууллаа.

НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй короновирусын халдвараар өвдсөн бага насны хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад “НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ” төсөлд халдвараар өвчилсөн 100 хүүхдийг хамруулан МУЗН, Улаан загалмайн сайн дурын идэвхтэнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Дэлхийн зөн ОНХ хамтран ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 02 дугаар сарын 25-нд хуралдаж 8 хүүхдийг комиссын хурлаар оруулж, шинээр 2 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлж, 6 хүүхдийн байнгын асаргааг дахин сунгаж, 5 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамрууллаа.

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** Энэ сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 920 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байна. Үүнээс 499 эрэгтэй, 421 нь эмэгтэй байна.

Тайлант сард бүртгэлтэй ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 51,2% нь бүрэн дунд, 31,4% нь дээд, 6,3% нь техникийн мэргэжлийн боловсролтой байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 34,1% нь 25-34 насны залуучууд, 15-24 насны залуучууд 14,1%-ийг, 35-44 насны иргэд 27,9% -ийг, 45-59 насны иргэд 20,9%-ийг тус тус эзэлж байна.

Ажлаас чөлөөлөгдөн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй 6 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн тодорхойлолт гарган өгсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын 2 дугаар сургуультай хамтран байгуулсан "Хөдөлмөр сургалтын төв"-р дамжуулан 8-11 дүгээр ангийн хүүхдүүдийн төлөөлөл 25 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгууллаа.

#### ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Говь-Алтай аймгийн Цогт сумын "Ээж хайрхан уулын" байгалын дурсгалт газарт нийтийн ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэг байгуулж жуулчин аялагч нарт тав тухтай орчин бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлыг хийж хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулж, Худалдан авах ажиллагааны газраар үнэлгээний хороо байгуулахаар ажиллаж байна.

НҮБХХ-ийн "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь-ensure" мон/19/301 төслийн захиалгаар "Эко болон тусгай аялал жуулчлал хөгжүүлэх төсөл" боловсруулах зөвлөх багтай уулзалт зохион байгууллаа.

#### НАЙМ.ОНЦГОЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн онцгой комиссыг 02 дугаар сарын 18-ны өдөр хуралдуулан Монгол Улсын Засгийн газрын Тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-ийг цуцалсантай холбогдуулан Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг "Шар түвшинд"-д 02 дугаар сарын 14-ний өдрөөс шилжүүлсэнтэй холбогдуулан орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлыг зэрэг"-ийг цуцлан "Шар түвшин"-д шилжүүлсэн.

#### ЕС.МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтаар:** Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт бус шалгалт хийж 3 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн биелэлтийг 100% хангуулж ажиллав.

**Авто замын хяналтаар:** Есөнбулаг сумын ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Мандал голомт ХХК-нд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 2 заалт бүхий албан шаардлага хүргүүлэв.

**Эрчим хүчний хяналтаар:** 2 байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 2 заалт бүхий 2 дүгнэлтийг үйлдэж холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

**Барилгын техникийн хяналтаар:** 2 байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 2 дүгнэлтийг үйлдэж холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

**Хэмжилзүйн хяналтаар:** Аудитын газраас ирүүлсэн албан тоотын дагуу Шинэ-Алтай захын 5 иргэний худалдаа үйлчилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгсэлд хяналт хийж ажиллав.

**Байгаль орчны хяналтаар:** Байгууллага, иргэдээс ирүүлсэн 7 өргөдлийн дагуу 3 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 450.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 5.9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулан 21 ширхэг тарвагыг аймгийн Зооноз өвчин судлалын төвд устгуулах арга хэмжээ авч ажиллав.

**Геологи, уул уурхайн хяналтаар:** Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, байгууллага, иргэдээс ирсэн гомдлын дагуу 6 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 900.0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдуулав.



**Газар, геодези зураг зүйн хяналтаар:** МХЕГ-аас ирүүлсэн 07/28/39 дугаартай албан бичгийн дагуу аэродромын хяналтын цэгээс 15 км доторх үйлдвэр, үйлчилгээний судалгаа гарган ажиллав.

**Авто тээврийн хяналтаар:** МХЕГ-аас ирүүлсэн 07/2839 дугаартай албан бичгийн дагуу аэродромын хяналтын цэгээс 15 км доторх 34 үйлдвэр, үйлчилгээний судалгааг гарган нэгтгэж МХЕГ-т хүргүүлж ажиллав.

**Хэмжилзүй, Авто тээвэр, байгаль орчны хяналтаар:** Аймгийн Засаг даргын А/58 дугаартай захирамжийн дагуу аймгийн авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгуулагын үйл ажиллагаанд ангилал тогтоох, тохиролын гэрчилгээ олгох ажлын хэсэгт орж урьдчилсан төлөвлөгөө, судалгаа гаргаж ажиллав.

**Мал эмнэлэг, мал үржлийн хяналтаар:** Улсын байцаагчдын чадавхижуулах сургалтад Мал эмнэлэг, мал үржлийн хяналтын улсын байцаагч нар хамрагдав.

“Дэлхийн Зөн” ОУБ-аас мал эмнэлгийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрт сургалтын хүрээнд Чандмань сумд 5 багийн 60 малчин хамруулан 10 ярилцлага зохион байгуулан тайланг хүргүүлэв.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР